



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Хөрсний ус гарч халиа дошин
үүссэн хороодод зохион байгуулалтын
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь заалт, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн зарим хороодод хөрсний болон булгийн ус гадагшилж хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн байршлуудад шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


2. Халиа дошин үүссэн хороодын байршлуудад шаардлагатай арга хэмжээг авч, эрсдэлийг тухай бүр нь бууруулж ажиллахыг Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ (Х.Нэмэхбаяр)-т, Захиалагчийн алба ОНӨААТҮГ (Д.Алтанхуяг)-т тус тус даалгасугай.

3. Тус ажилд шаардагдах зардлыг тухай бүрд нь батлагдсан тарифын хүрээнд тооцож, баталгаажсан гүйцэтгэлийн бичиг, баримтыг үндэслэн гүйцэтгэлээр Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Тамгын газар (Ж.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг дүүргийн Менежер (Д.Баярсайхан)-т үүрэг болгосугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2024 оны А/165 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТТӨР

E:\2026\Засаг дарга\Захирамж.docx

1826010125

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн
1/16 дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Дүүргийн менежер

Ажлын хэсгийн гишүүд:

Засаг даргын Тамгын газрын дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Хотын стандарт, тохижилт, нийтийн аж
ахуйн хэлтсийн дарга

Онцгой байдлын хэлтсийн дарга

Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ-ын
захирал

Захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын захирал

Газар зохион байгуулалтын албаны дарга

Хороодын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

Хотын стандарт, тохижилт, нийтийн аж
ахуйн хэлтсийн Дэд бүтэц, инженерийн
байгууламжийн хариуцсан мэргэжилтэн